



SMART LOGIC

ПРОГРАМ ХАНГАМЖ & МТ ҮЙЛЧИЛГЭЭ

Пүрчүлж алхана

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



Copyright 2020 © SmartLogic LLC
All Rights reserved

АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ	3
КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА	4
АЛСЫН ХАРАА	4
ЭРХЭМ ЗОРИЛГО	4
ҮНЭТ ЗҮЙЛС	5
КОМПАНИЙН БҮТЭЦ	5
ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС	5
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД	6
ҮЙЛЧИЛГЭЭ	6
SMART ERP-ийн ДЭД СИСТЕМҮҮД	7
SMART BI - УДИРДЛАГЫН ТАЙЛАНГИЙН СИСТЕМ	8
SMART ACCOUNTING - САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АХИСАН ТҮВШНИЙ СИСТЕМ	9
SMART RETAIL - ДЭЛГҮҮРИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ	10
SMART RESTAURANT - РЕСТОРАНЫ УДИРДЛАГЫН СИСТЕМ	11
SMART RETAIL POS - ДЭЛГҮҮРИЙН КАССЫН СИСТЕМ	12
SMART RESTAURANT POS - РЕСТОРАНЫ КАССЫН СИСТЕМ	12
SALE & DISTRIBUTION - БОРЛУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН СИСТЕМ	13
SMART LOYALTY (B2C) - ГИШҮҮНЧЛЭЛИЙН КАРТЫН СИСТЕМ	14
SMART HR - ХҮНИЙН НӨӨЦИЙН СИСТЕМ	15
SMART TIME & ATTENDANCE - ЦАГ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ	16
SMART HOTEL - ЗОЧИД БУУДЛЫН СИСТЕМ	17
SMART PHARMACY - ЭМИЙН САНГИЙН СИСТЕМ	18
SMART BALANCE PRO - САНХҮҮ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ДУНД ТҮВШНИЙ СИСТЕМ	19
SMART POS - КАССЫН СИСТЕМ	20
SMART MRP - БАРААНЫ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ	21
НЭМЭЛТ СИСТЕМСҮҮД	22
SMART ACADEMY ТУХАЙ	25
ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД	26

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм танд энэ өдрийн мэнд хүргэе!

Смарт Ложик ХХК нь 2014 оноос хойш мэдээллийн технологи, програм хангамж, зөвлөх үйлчилгээ, сургалтын үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Мэдээллийн технологийн салбар нь өнөөгийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч голлох салбар болон хөгжиж, улс орнуудын нийгэм, эдийн засаг, бизнесийн байгууллага, хувь хүний хөгжлийн хурдасгагч нэгэн хүчин болж, ач холбогдол нь өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байгаа билээ.

Энэхүү эрчимтэй өсч буй мэдээллийн технологийн эрин зуунд бизнесийн байгууллагууд нь тогтвортой, хурдтай, өсөлттэй, өрсөлдөхүйц, тасралтгүй үйл ажиллагаа явуулахад зайлшгүй мэдээллийн технологийн хөгжил дэвшлийг ашиглах шаардлагатай болж байна.

Бид мэдээллийн технологийн салбар дахь 10 гаруй жилийн туршлага дээрээ үндэслэн бизнесийн байгууллагуудад зориулсан "Smart ERP-Бизнесийн байгууллагын цогц систем" -ийг хөгжүүлэн одоогоор 1200 гаруй байгууллагад нэвтрүүлснээр, 7000 гаруй хэрэглэгч өдөр тутамдаа ашиглаж байна.

Бид харилцагчдаа хүргэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ үргэлж чанар, инновацлаг байдлыг эрхэмлэж, тэдний хэрэгцээ шаардлагад нь нийцсэн байхын төлөө өдөр бүр хичээн ажилладаг.

Манай бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгосон харилцагч та бүхэндээ баярлалаа. Та нарынхаа найдвартай түнш нь байхын төлөө хичээн ажиллах болно.

Та бүхний ажилд нь амжилт, амьдралд тань аз жаргалыг хүсье !

Ерөнхий захирал Б.АНХБАЯР

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе!

Өнөөдрийн "СМАРТЛОЖИК ХХК" -ийн үйл ажиллагааны цар хүрээ, гаргасан амжилт ололт бүхэн чадварлаг ажилтнуудын маань хөдөлмөр хичээл зүтгэл төдийгүй, хэрэглэгч харилцагч нэг бүрийн сэтгэлийн дэмжлэг гэдгийг хэлэхэд таатай байна.

Бид өнгөрсөн хугацаанд хамгийн тохиромжтой технологи ашиглан SMART ERP бүтээгдэхүүнээ хөгжүүлж зах зээлд амжилттай нийлүүлж нэвтэрүүлсэн билээ.

Технологи хурдацтай хөгжихийн хэрээр хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлага асар хурдацтай өөрчлөгдөж байна.

Тиймээс ч бид хөгжлийн ирэх 5 жилдээ дэлхийн технологийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах CLOUD технологийн эрин үерүү орох судалгаа, бэлтгэл ажилдаа аль хэдийн орсон байна.

Smart ERP-ийг сонгон үйлчлүүлдэг эрхэм харилцагч та бүхэндээ баярлалаа.

Технологи хариуцсан захирал Ө.АЗАМАТ

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



Смарт Ложик ХХК нь 2014 оноос эхлэн Програм хангамж хөгжүүлэх (Software Development), Мэдээлэл Технологийн үйлчилгээ үзүүлэх (IT Services),

Мэргэжлийн сургалт явуулах (IT Training) чиглэлээр бизнесийн болон төрийн бүх түвшний байгууллагад зориулсан цогц системийг хөгжүүлж, нийлүүлж, суурилуулж ирсэн билээ.

Бид дэлхийн технологийн хөгжлийн чиг хандлага болсон ERP, BI, HR, CRM - системүүдийг боловсруулан хөгжүүлж байгаа ба өөрийн нэрийн SMART ERP - системийг зах зээлд нийлүүлээд байна.

Өнөөдрийн байдлаар SMART ERP - систем нь дотроо 40 гаруй дэд системтэй болон өргөжиж дотоодын 1200 гаруй байгууллагад амжилттай нэвтрээд байна.

АЛСЫН ХАРАА

"We strive to become a global software, IT training and consulting company"

Бид дэлхийн түвшний програм хангамж, IT сургалт, зөвлөх үйлчилгээний компани болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

"We are passionate in helping our customers through innovative products and services to maximize their business dreams"

Бид маш их хүсэлт тэмүүлэлтэйгээр өөрсдийн ухаалаг, инновацлаг бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ харилцагч нарынхаа бизнес мөрөөдлийг максимум түвшинд биелүүлэхэд туслана.

ҮНЭТ ЗҮЙЛС



INNOVATION - Инноваци

Бидний бүх бүтээгдэхүүн, үйлчилгээ, ажиллах орчин гэх мэт зүйлсд инноваци шингэсэн байна.



TEAMWORK - Багийн ажиллагаа

Бид багын системээр ажилладаг. Хамтдаа хүчтэй.



INTEGRITY - Шударга

Бид аливаад хуулийн дагуу, шударга зан чанарыг эрхэмлэнэ



EXCELLENCE - Төгс

Бид ажлыг төгс хийдэг. Бидний бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бусад бүх зүйлсээс төгс гэсэн үнэр үнэртэнэ.



KNOWLEDGE - Мэдлэг

Бид өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлдэг байна. Мэдлэгийг харилагч нартаа болон бие биедээ түгээдэг байна. Мэддэг юм шиг байх биш баталгаажуулсан мэдлэгтэй байх.



CARING - Халамжлах

Биднийг сонгосон харилцагч нараа халамжилдаг байна. Үнэ цэнийг бүтээж байгаа ажилтнуудаа халамжилдаг байна.

КОМПАНИЙН БҮТЭЦ



ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС





40+

Ажилтны тоо



40+

Бүтээгдэхүүн



1,200+

Харилцагчийн
тоо

20+

Захиалгат төсөл

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Макс групп, Наран групп компаниудад Smart ERP-цогц програмаа нэвтрүүлэв.
- Дотоод үйл ажиллагаандаа CRM систем нэвтрүүлж, үйл ажиллагаагаа автоматжуулав.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд Нийслэлийн засаг даргын тамгын газрын мэдээллийн технологийн газартай хамтран tsetserleg.ulaanbaatar.mn, tsetserleg UB апп хөгжүүлэв
- Horeco-Хотел, рестораны чиглэлийн холбооны үзэсгэлэнд жил бүр оролцож, Smart ERP цогц бүтээгдэхүүнээ танилцуулав.
- Эрдэнэт үйлдвэрийн Мэдээллийн технологийн алба-д консалтинг үйлчилгээ үзүүлэв.
- Датакейр ХХК-ын Имарт төслийн систем дээр консалтинг үйлчилгээ үзүүлэв.
- АШУҮИС-н эмнэлгийн системийн төсөл дээр консалтинг үйлчилгээ үзүүлэв.
- Хамтын ажиллагааны хүрээнд томоохон арилжааны банкууд /Хаан, Голомт, Худалдаа хөгжил, Хас банк/, Мобиком/Candy/, Юнайтид алейнс/Upoint/, МЧат/Монгол чат/, Social pay, Т-Финанс /Домог/ гэх мэт сүүлийн үед хэрэглээ болсон апп болон банкны терминалуудтай холбогдов.
- ICT спортын их наадамд 3 төрөлд оролцов.
- Бүх харилцагчдыг хамарсан нэгдсэн сургалтыг сүүлийн 3 жил дараалан хийв.
- МОСА, ХСНХ гишүүн болов.

ҮЙЛЧИЛГЭЭ



ПРОГРАМ ХАНГАМЖ БОЛОВСРУУЛАХ

Бүх төрлийн (Десктоп, Веб, Мобайл) програм хангамжийг захиалгаар боловсруулна.



ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Програм хангамж нь 1 жилийн баталгаат хугацаатай байх бөгөөд энэ хугацаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үнэгүй.



BUSINESS INTELLIGENCE & DATA WAREHOUSING - ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭ

Right Information, Right People, Right Time, Any where, Any device, Decide & Act



ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бүх төрлийн програм хангамжийн архитектур дизайн болон кодчиллын үе шатанд зөвлөгөө өгнө.



САНХҮҮГИЙН ПРОГРАМЫН СУРГАЛТ

Smart Accounting, Smart Balance - санхүүгийн програмууд дээр сургалт явуулна.



IT TRAINING

IT Training for certificates - Microsoft SQL Server, Dot.Net, C#, Oracle Database, Java SE, Java EE, Power BI




SMART ERP

ЦОГЦ СИСТЕМ



SMART ERP-ийн ДЭД СИСТЕМҮҮД





SMART BI - УДИРДЛАГЫН ТАЙЛАНГИЙН СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Мэдээллийн технологи хөгжихийн хэрээр бизнесийн байгууллагууд мэдээлэл дээр үндэслэсэн зөв шийдвэр гаргадаг болж байна. Smart BI - удирдлагын тайлангийн систем нь Smart ERP - дэд системүүдэд орсон мэдээллийг автоматаар боловсруулан тайлан, дашбордуудыг

хэрэглэгчид ойлгомжтой байдлаар харуулан, ухаалаг зөв шийдвэр гаргахад тань тусална. Smart BI - системийг ашигласнаар шийдвэр гаргах процессийг сайжруулж, учирж болох эрсдийг тооцоолж, цаг хугацааг хэмнэх болно.

ДАВУУ ТАЛ:

- Дэлхийн хаанаас ч
- Гар утас, таблет, ухаалаг төхөөрөмжөөр
- Цаг хугацаа хэмнэсэн, мэдээллийг хурдан шуурхай авах
- 400 гаруй тайлан, дашборд
- Хүний оролцоогүй
- Мэдээллийн харьцуулалт автоматаар харагдах
- Шийдвэр гаргахад туслах хэрэгсэл



EXECUTIVES ЗАХИРЛУУД



BUSINESS DECISION MAKERS БИЗНЕС ХӨГЖҮҮЛЭЛТИЙН МЕНЕЖЕРҮҮД



ANALYSTS ШИНЖЭЭЧИД



СИСТЕМИЙН МОДУЛИУД

1. САНХҮҮ, МӨНГӨН УРСГАЛ, АШИГ АЛДАГДАЛ, БОРЛУУЛАЛТ, БАРАА МАТЕРИАЛ, ӨГЛӨГ & АВЛАГА, ОРЛОГЫН ТАЙЛАН, САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ (150+ТАЙЛАН/ДАШБОРД)

- Өр төлбөр, эздийн өмч, орлого, зарлага графикаар харах боломж
- Мөнгөний үлдэгдэл, валютаар, урсгал хугацаануудаар харах боломж
- Нийт ашиг, цэвэр ашиг тэдгээрийн өсөлт, бууралт, өмнөх жилүүдтэй харьцуулан харах боломж
- Борлуулалтын өсөлт бууралт, ангилалаар, харилцагчаар, бараагаар, байршлаар гэх мэт бүх төрлийн борлуулалттай холбоотой шинжилгээг авах боломж
- Барааны нөөцийн мэдээлэл, ABC ангилал, Топ 10 бараа гэх мэт бараатай холбоотой бүх төрлийн шинжилгээ харах боломж
- Зардлын төрлөөр, топ зардлууд, дансаар, төсөвтэй харьцуулан харах боломж
- Өглөг, авлагын үлдэгдэл, насжилтаар, харилцагчаар харах боломж
- Орлогын тайланг хүссэн хугацаагаар болон өмнөх жилүүдтэй харьцуулах, тайлангийн үзүүлэлтээр харьцуулах боломж
- Эдгээр бүх шинжилгээг хугацаагаар, өмнөх жилүүдтэй харьцуулан хүснэгт болон графикаар авах боломжтой

2. ДЭЛГҮҮРИЙН СИСТЕМИЙН БОРЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ (50+тайлан/дашборд)

3. РЕСТОРАНЫ СИСТЕМИЙН БОРЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ (50+тайлан/дашборд)

4. ТҮГЭЭЛТИЙН СИСТЕМИЙН БОРЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ (50+тайлан/дашборд)

5. ХӨНГӨЛӨЛТИЙН КАРТЫН СИСТЕМИЙН ХЯНАЛТ (50+тайлан/дашборд)

6. ХҮНИЙ НӨӨЦИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТ (50+тайлан/дашборд)

7. ЗОЧИД БУУДЛЫН СИСТЕМИЙН ХЯНАЛТ (50+тайлан/дашборд)

8. ЦАГ, БҮРТГЭЛИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТ (50+тайлан/дашборд)



SMART ACCOUNTING - САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АХИСАН ТҮВШНИЙ СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Санхүү, НББ - ын систем нь бизнесийн байгууллагуудын санхүү, НББ бүртгэл, данс хөтлөлт, тайлан зэргийг Монгол улсад болон ОУ-д мөрдөгдөж буй НББ стандартууд, Санхүүгийн тайлагналын ОУ-ын стандартуудыг хангасан санхүүгийн цогц систем юм. Энэхүү систем нь

бүхий л салбарын онцлог, хэрэгцээнд бүрэн зохицон ажиллахаар хөгжүүлэгдсэн бөгөөд байгууллагын бүхий л санхүүгийн үйл ажиллагааг автоматжуулж, зөв тайлан гаргаж, цаг хугацаа хэмнэж, ухаалаг зөв шийдвэрүүдийг гаргахад тань тусална.

ДАВУУ ТАЛ:

- Санхүү, татварын тодруулах тайлан гарна
- Олон валютын боломжтой
- Валютын ханшийг монгол банкнаас автоматаар татна
- Эхний үлдэгдэл болон гүйлгээг Exsel-ээс импортлох боломжтой
- Няравын боломжтой
- Анхан шатны баримтууд хэвлэх боломжтой
- Автомат баримтын дугаарлалт
- Хэрэглэхэд хялбар, ойлгомжтой
- Гүйлгээ шивэхэд маш хурдан
- Бүх төрлийн гүйлгээг хуулан дахиж шинээр гүйлгээ үүсгэх боломжтой
- Бүх тайлан, жагсаалтаас Exsel, PDF-рүү экспортлох боломжтой
- Тайлангийн дүнгээс хөөж ажил гүйлгээгээ харж, засварлах боломжтой (DRILL DOWN)
- Цалингийн мэдээллийг и-мэйлээр илгээх боломжтой
- Банкны хуулгыг Exsel-ээс татах боломжтой
- Гар утсан дээрээс зөвшөөрөл олгох боломжтой





SMART RETAIL - ДЭЛГҮҮРИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Дэлгүүрийн цогц систем нь ПОС- оор борлуулалт хийдэг нэг болон олон салбартай дэлгүүр болон худалдааны байгууллагад зориулсан систем юм. Энэхүү системийг хэрэглэснээр танай байгууллагын борлуулалт, бараа материал,

тооллогын үйл ажиллагааг автоматжуулж, цаг хугацаа хэмнэж, үр ашиг авчирна. Уг систем нь Санхүү, лоялти, удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Олон салбар дэлгүүр ашиглах боломжтой.
- Санхүүгийн болон хөнгөлөлтийн картын системүүдтэй холбогдон ажиллах боломжтой.
- Smart BI удирдлагын системтэй холбогдож ажиллана.
- Хөнгөлөлт урамшууллыг дурын нөхцөлөөр тохируулах боломжтой.
- Барааны нийт ашгийг харах боломжтой.
- Барааны үлдэгдлээ бодитоор харах боломжтой.
- Борлуулалтын төлөвлөгөө оруулж гүйцэтгэлийг харьцуулан харах боломжтой.
- Өглөг, авлага тайлан хянах боломжтой.
- НӨАТУС-тай холбогдсон
- Багц баримт илгээнэ.
- Бэлэг боох боломжтой.
- Борлуулалтын буцаалт хийх, бараа солих боломжтой.
- Баримтыг хэсэгчлэн буцаах боломжтой.
- Бараа бүтээгдэхүүний орц найрлагыг тохируулах боломжтой.
- Борлуулалтын өдрийн хаалт, нээлт ашиглах боломжтой.
- Бүх тайлан, жагсаалтаас EXCEL, PDF-рүү экспортлох боломжтой.





SMART RESTAURANT - РЕСТОРАНЫ УДИРДЛАГЫН СИСТЕМ


СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Ресторан, паб, лаунж, караоке, кофе шопд зориулагдсан борлуулалтын үйл ажиллагаа хөнгөвчилсөн, үнэ хөнгөлөлт урамшууллын уян хатан бодлоготой, төлөвлөлт, бүх төрлийн

банкны карттай холбогдон ажиллах цогц шийдэл юм. Уг систем нь санхүүгийн систем, хөнгөлөлтийн систем, зочид буудлын системтэй уялдан ажиллана.

ДАВУУ ТАЛ:

- Технологийн карт, орц норм тохируулах боломжтой.
- Технологийн картын дагуу материал зарцуулалтаа хянах боломжтой.
- Уух зүйлсийг граммаар тохируулах боломжтой.
- Санхүүгийн болон хөнгөлөлтийн карт, зочид буудал системүүдтэй холбогдон ажиллах боломжтой.
- Smart BI удирдлагын системтэй холбогдож ажиллана.
- Барааны нийт ашгийг харах боломжтой.
- Барааны үлдэгдлээ бодитоор харах боломжтой.
- Борлуулалтын төлөвлөгөө оруулж гүйцэтгэлийг харьцуулан харах боломжтой.
- Заал болон ширээг өөрөө тохируулах боломжтой.
- Хоол болон уух зүйлсийн меню хүссэнээрээ тохируулах боломжтой.
- Борлуулалтын төлөвлөгөө гүйцэтгэл гаргах боломжтой.
- Борлуулалтын буцаалт хийх, бараа солих боломжтой.
- Борлуулалтын өдрийн хаалт, нээлт ашиглах боломжтой.
- Бүх тайлан, жагсаалтаас EXCEL, PDF – рүү экспортлох боломжтой.





SMART RETAIL POS - ДЭЛГҮҮРИЙН КАССЫН СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Дэлгүүрийн ПОС систем нь жижиглэн борлуулалт хийхтэй холбоотой нэг болон олон салбар дэлгүүрүүд зориулсан систем юм. Уг систем нь дэлгүүрийн удирдлагын систем болон хөнгөлөлтийн картын системтэй уялдаж ажилладаг.

ДАВУУ ТАЛ:

- Касс дээр барааны үлдэгдэл харах боломжтой.
- Борлуулагч сонгон борлуулалт хийх боломжтой.
- Хүлээлгийн горимтой.
- НӨАТУС-тэй холбогдсон.
- Хаан банк, Хас банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Датабанкны E-POS терминалтай холбогдсон
- Social pay, Candy, Mongol Chat, UPoint ашиглан төлбөр төлөх боломжтой.
- Хөнгөлөлт, бонус карт ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой.
- Ажилтны цаг бүртгэл хийх боломжтой.
- Бэлгийн карт, ваучер, эрхийн бичиг, кредит карт ашиглах боломжтой.
- Хэвлэх билл дээр хүссэн мэдээллээ нэмж оруулах боломжтой.
- Сүлжээнд холбогдоогүй горимд ажиллах боломжтой.
- Борлуулалтаа автоматаар төв сервер рүү илгээх боломжтой.
- Харилцагчийн дэлгэц, мөнгөний хайрцаг ашиглах боломжтой.
- Кассын орлого зарлагыг бүртгэх боломжтой.
- Тухайн борлуулалтад хөнгөлөлт ашиглах боломжтой.
- Барааны захиалга хийх боломжтой.



SMART RESTAURANT POS - РЕСТОРАНЫ КАССЫН СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Ресторан ПОС систем нь ширээний захиалга авах, шууд борлуулалт хийх, ширээ шилжүүлэх, зөөгчийн хяналт, тогоочийн хяналт хэсэгтэй үйлчлүүлэгчид түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд нь тусална. Уг систем нь Рестораны удирдлагын систем болон хөнгөлөлтийн картын системтэй уялдаж ажилладаг.

ДАВУУ ТАЛ:

- Касс дээр барааны үлдэгдэл харах боломжтой.
- Цагийн тохиргоо ашиглах боломжтой.
- Захиалсан бэлэн бүтээгдэхүүний аль шатанд явж байгааг зөөгч хянах боломжтой.
- НӨАТУС - тэй холбогдсон.
- Хаан банк, Хас банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Датабанкны E-POS терминалтай холбогдсон
- Social pay, Candy, Mongol Chat, UPoint ашиглан төлбөр төлөх боломжтой.
- Хөнгөлөлт, бонус карт ашиглаг төлбөр тооцоо хийх боломжтой.
- Бэлгийн карт, ваучер, эрхийн бичиг, кредит карт ашиглах боломжтой.
- Хэвлэх билл дээр хүссэн мэдээллээ нэмж оруулах боломжтой.
- Сүлжээнд холбогдоогүй горимд ажиллах боломжтой.
- Борлуулалтаа автоматаар төв сервер рүү илгээх боломжтой.
- Кассын орлого зарлагыг бүртгэх боломжтой.
- Тухайн борлуулалтад хөнгөлөлт ашиглах боломжтой.
- Ажилтны цагын бүртгэл хийх боломжтой.
- Тогоочын дэлгэц ашиглах боломжтой.



SALE & DISTRIBUTION - БОРЛУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН СИСТЕМ


СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Борлуулалт түгээлтийн систем нь бараа бүтээгдэхүүнээ түгээлт хийж борлуулалдаг импортын компани, дотоодын үйлдвэр болон бэлтгэн нийлүүлэгчдэд зориулсан систем юм. Энэхүү системийг ашигласнаар байгууллагын агуулахын үйл ажиллагааг сайжруулж, борлуулалт

түгээлтийн процессыг автоматжуулж, цаг хугацаа хэмнэж, ухаалаг шийдвэрүүдийг гаргахад тань тусална. Уг систем нь Санхүү, удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм

ДАВУУ ТАЛ:

- Сүлжээний горимд нэг баазруу олон хэрэглэгч хандан ашиглах боломжтой
- Худалдааны төлөөлөгчийн онлайн захиалга
- Захиалга дээр хөнгөлөлт, урамшуулал тооцох боломжтой
- Гар утас, зөөврийн төхөөрөмж дээр агуулахын бодит үлдэгдэл (Realtime) харах
- Захиалсан тоог бүртгэн боломжит үлдэгдэл хөтлөх
- Хэрэглэхэд хялбар ойлгомжтой
- Урамшуулал, хөнгөлөлтийн уян хатан нөхцөлтэй
- Түгээгч гар утаснаас хүргэлт хийх, газар дээр анхан шатны баримт хэвлэх
- Түгээгч газар дээр нь тоо хэмжээ өөрчлөх, шинээр бүртгэх боломжтой
- Түгээгч гар утаснаас тоо хэмжээ өөрчлөсөн тохиолдолд урамшуулал, хөнгөлөлт дахин тооцох боломжтой
- Түгээгчийн үлдэгдэл хөтлөх, өөрийн үлдэгдэл хянах, шилжүүлэх боломжтой
- Нярав агуулхаас бараа гарган ачилтыг бүртгэх
- Бараа материалын хөдөлгөөн бүртгэх боломжтой
- Борлуулалттай холбоотой бүх төрлийн тайлан шинжилгээ хийх боломжтой
- Бүх тайлан, жагсаалтаас EXCEL, PDF-рүү экспортлох боломжтой
- Харилцагчийн буцаалтын бараагаар, баримтаар бүртгэх боломжтой
- Худалдааны төлөөлөгч, түгээгчийн GPS-н хяналт, явсан замын мэдээлэл
- Харилцагчийн цэгийн бүртгэл, маршрутын хяналт
- Зээлийн лимитийн бүртгэл
- Газрын зураг дээр маршрут, бүс зурах боломжтой





SMART LOYALTY (B2C) - ГИШҮҮНЧЛЭЛИЙН КАРТЫН СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Бүх төрлийн дэлгүүр, зочид буудал, рестораны үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд өөрсдийн байнгын худалдан авагчаа таниж мэдэх, тэдгээрийг урамшуулах, хөнгөлөх боломжоор хангахад туслах цогц систем юм. Энэхүү систем нь харилцагчийн худалдан авалтын хөнгөлөлт,

бонусыг удирдах, ваучер, бэлгийн карт, кредит карт гэсэн карт үүсгэж, харилцагчийн зан төлвийн судалгаа хийх, удирдлагын шийдвэр гаргалтанд тусална. Уг систем нь санхүү, дэлгүүр, ресторан болон удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Групп компанийн түвшинд ашиглах боломжтой
- Нэг картыг олон хэрэглэгч хамтран эзэмших боломжтой
- Хэрэглэгчийн хурууны хээг бүртгэж, хурууны хээгээр таних боломжтой
- Олон төрлийн хөнгөлөлт, бонус, урамшууллуудыг зохиох боломжтой
- Кредит карт, ваучер ашиглах боломжтой
- Харилцагчийн худалдан авалтын мэдээлэл дээр үндэслэн хэрэглэгчийн зан төлвийг тодорхойлж шууд маркетинг хийх боломжтой
- Шилдэг харилцагчид буюу байнгын үйлчлүүлэгчдийг мэдэх боломжтой
- Худалдан авалтын тайлан мэдээн дээр үндэслэн бүх төрлийн тайлан мэдээлэл авах боломжтой
- Бүх тайлан, жагсаалтуудыг Excel, Pdf файл болгон хөрвүүлэн авах боломжтой
- Ресторан болон дэлгүүрийн талоны задаргааг гишүүн тус бүрээр харан, анализ хийх боломжтой
- Санхүүгийн системтэй холбогдох боломжтой
- Карт эзэмшигчдэд зориулсан мобайл аппликейшнтэй
- Карт эзэмшигчдээс дурын нөхцөлөөр шүүж и-мэйл, sms илгээж масс маркетинг хийх боломжтой

ЕРӨНХИЙ ТОХИРГОО

- Хэрэглэгчийн бүртгэл
- Картын төрлүүд үүсгэх

БҮТЭЦ

МЭДЭЭЛЭЛ БИЙ БОЛГОХ

- Карт бүртгэл
- Карт эзэмшигчийн бүртгэл
- Карт эзэмшигчийн ангилал
- Бизнесийн төрлүүд бүртгэл
- Ваучер бүртгэл

ҮР ДҮН, ХЯНАЛТ

- Бүх төрлийн тайлан
- Удирдлага хяналт

SMART LOYALTY ГИШҮҮНЧЛЭЛИЙН КАРТЫН СИСТЕМ

ИДЭВХЖҮҮЛЭЛТ

- Хөнгөлөлтийн карт
- Бонус карт
- Онооны карт
- Урамшуулал
- Ваучер
- Кредит карт
- Худалдан авалт

УРАМШУУЛАЛ ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ

- Хөнгөлөлт, бонусын хувь шатлалаар тооцох
 - Дансанд хуримтлагдах
- Кредит картны ашиглалт тооцож, авлага үүсгэх

БАТАЛГААЖУУЛАЛТ

- Дэлгүүр
- Ресторан
- Эмийн сан
- Зочид буудал
- Кофе шоп



SMART HR - ХҮНИЙН НӨӨЦИЙН СИСТЕМ


СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын хүний нөөц төлөвлөлт, бүртгэл, хөдөлмөрийн харилцаа, сургалт хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ гэх мэт бүхий л үйл ажиллагааг автоматжуулсан цогц систем юм.

Энэхүү систем нь хүний нөөцийн менежерийн ажиллах програм, ажил горилогчийн анкетийн вэб, ажилтны вэб гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Уг систем нь санхүү, цаг бүртгэл, удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Групп компанийн түвшинд ашиглах боломжтой
- Байгууллагын бүтцийг хэлтэс тасаг, нэгж бүрээр үүсгэх, тэдгээртэй ажилтнуудаа тохируулах боломжтой
- Санхүүгийн систем, цаг бүртгэлийн системтэй холбогдох боломжтой
- Ажилтны вэбээр ажилтнууд өөрийн эрхээр нэвтэрч анкетын мэдээллийг харах, төлөвлөгөө гүйцэтгэл хөтлөх, чөлөө ээлжийн амралтын хүсэлт гаргах, цалингийн мэдээ, цагийн мэдээ, өглөг авлагын мэдээ, үндсэн хөрөнгийн мэдээ, хангамжийн материалын, тушаал, гэрээний мэдээллүүдийг авах боломжтой
- Ажилтны анкетын бүх мэдээллээр жагсаалт, тайлан мэдээ шүүж авах боломжтой
- Гэрээ, тушаал, шилжилт хөдөлгөөний бүртгэлүүд хөтлөх, тайлан мэдээ авах боломжтой
- Хөдөлмөрийн харилцааны тайлан мэдээг шүүж, татах боломжтой
- Бүх тайлан, жагсаалтуудыг Excel, Pdf файл болгон хөрвүүлэн авах боломжтой





SMART TIME & ATTENDANCE - ЦАГ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ


СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Цаг бүртгэлийн төхөөрөмжүүдээс нүүр, хурууны мэдээллийг татаж боловсруулан тогтмол цагийн хуваарь болон ээлжийн цагийн хуваарийн дагуу ажилладаг бүхий л байгууллагад тохирох систем юм. Энэхүү систем нь цагийн бүртгэлтэй

холбоотой бүхий л ажиллагааг автоматжуулж, цаг хугацаа хэмнэж, ухаалаг зөв шийдвэрүүдийг гаргахад тань тусална. Уг систем нь санхүү, хүний нөөц, удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Сүлжээний горимд нэг бааз руу олон хэрэглэгч хандан ажиллах боломжтой
- Цаг бүртгэлийн ямарч төхөөрөмжтэй холбогдон ажиллах боломжтой
- Хэрэглэхэд хялбар ойлгомжтой
- Байгууллагын үндсэн цагийн хуваарийг тохируулах боломжтой
- Үндсэн цагийн хуваариас гадна хэлтэс тасгаар болон ажилтнаар ялгаатай цагийн хуваарь оруулах боломжтой
- Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдийг бүртгэхдээ бүх ажилтан, хэлтэс тасгаар, ажилтнаар, албан тушаалтнаар тохируулах боломжтой
- Ажилтны шилжилт хөдөлгөөнийг бүртгэх боломжтой
- Зөрчлийн хяналтаар цагийн зөрчилтэй ажилтнуудыг анхааруулахаас гадна засварласан мэдээллийн лог хөтлөх боломжтой
- Урт хугацаатай буюу чөлөө, ээлжийн амралт, өвчтэй, томилолт гэх мэт шалтгааны бүртгэл хийх боломжтой
- Цагийн балансын тайлангуудыг хүссэн загвараар авах боломжтой
- Санхүүгийн системийн цалингийн хэсэгтэй холбогдох боломжтой байна
- Хүний нөөцийн системтэй холбогдож тушаал шийдвэр, шилжилт хөдөлгөөн гэх мэт ажилтантай холбоотой мэдээллүүдийг авч тайлан мэдээ авах боломжтой
- Ажилтны вэб-н хэсэгтэй холбогдож тухайн ажилтны цагийн мэдээллийг харуулах, хүсэлт тавих боломжтой
- Удирдлага болон хэлтсийн дарга нарт ажилтнуудын цагийн мэдээллийг дашбордоор цаг алдалгүй авах боломжтой.





SMART HOTEL - ЗОЧИД БУУДЛЫН СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг бүхий л байгууллагын үйл ажиллагаа автоматжуулсан систем юм. Энэхүү систем нь зочид буудлын үйлчилгээний бүртгэлүүд, төлбөр тооцоо, тайлан

мэдээ нэгтгэх боломжтой. Уг систем нь Санхүү, ресторан, хөнгөлөлтийн карт, удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Өрөөний төрөл, өрөөгөөр үнэ тохируулах боломжтойгоос гадна зочин нэмэгдэхэд, ор нэмэхэд нэмэгдэх дүнг тохируулах боломжтой.
- Өрөөний төрлөөр улирал үүсгэн хугацааны давтамжтайгаар хэрэгжих үнэ тохируулах боломжтой.
- Урьдчилсан захиалга бүртгэхдээ өрөөгөөр нь болон группээр нь захиалга авах боломжтой.
- Өрөөтэй холбоотой төлөв хөтлөлт (Дотоод хяналт).
- Рестораны системтэй холбогдох зочны төлбөр төлөлт дээр харагдах.
- Зочинтой холбоотой зочин оруулах, гаргах, өрөө шилжүүлэх бүхийл үйлдлийг системээр хийх.
- Санхүүгийн системтэй холбогдох боломжтой.
- Хэрэглэхэд хялбар ойлгомжтой.
- Бүх тайлан, жагсаалтаас EXCEL, PDF - рүү экспортлох боломжтой.





SMART PHARMACY - ЭМИЙН САНГИЙН СИСТЕМ


СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Эмийн сангийн цогц систем нь ПОС- оор борлуулалт хийдэг нэг болон олон салбартай эмийн сан болон эмийн борлуулалттай байгууллагад зориулсан систем юм. Энэхүү системийг хэрэглэснээр танай байгууллагын

борлуулалт, бараа материал, тооллогын үйл ажиллагааг автоматжуулж, цаг хугацаа хэмнэж, үр ашиг авчирна. Уг систем нь Санхүү, лоялти, удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Олон салбар эмийн сангууд ашиглах боломжтой.
- Санхүүгийн системүүдтэй холбогдон ажиллах боломжтой.
- Хөнгөлөлт урамшууллыг дурын нөхцөлөөр тохируулах боломжтой.
- Барааны нийт ашгийг харах боломжтой.
- Барааны үлдэгдлээ хянах боломжтой.
- ЭМД-ын хөнгөлөлттэй борлуулах боломжтой.
- ЭМД-ын цахим системтэй холбогдоно.
- Бэлэг орцтой бүтээгдэхүүн тохируулах боломжтой.
- НӨАТУС илгээнэ.
- Борлуулалтын буцаалт хийх, бараа солих боломжтой.
- Бүх тайлан, жагсаалтаас EXCEL, PDF-рүү экспортлох боломжтой.





SMART BALANCE PRO - САНХҮҮ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ДУНД ТҮВШНИЙ СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Санхүү, НББ - ын систем нь бизнесийн байгууллагуудын санхүү, НББ бүртгэл, данс хөтлөлт, тайлан зэргийг Монгол улсад болон ОУ-д мөрдөгдөж буй НББ стандартууд, Санхүүгийн тайлагналын ОУ-ын стандартуудыг хангасан

санхүүгийн дунд түвшний систем юм. Энэхүү систем нь байгууллагын бүхий л санхүүгийн үйл ажиллагааг автоматжуулж, зөв тайлан гаргаж, цаг хугацаа хэмнэж, ухаалаг зөв шийдвэрүүдийг гаргахад тань тусална.

ДАВУУ ТАЛ:

- Сүлжээний горимд нэг бааз руу олон хэрэглэгч хандан ажиллах боломжтой
- Олон валютын бүртгэл хөтлөх боломжтой
- Валютын ханшийг монгол банкнаас автоматаар татна
- Валютын ханшийн тэгшитгэ хийх боломжтой
- Эхний үлдэгдэл болон гүйлгээг EXCEL-с импортлох боломжтой
- Суурилуулах хэрэглэхэд хялбар энгийн ойлгомжтой
- Цалин цагийн мэдээллийг мэйлээр илгээх боломжтой
- Цалингийн мэдээллийг НД, Татварын веб сайтруу эксел файлаар шууд татах боломжтой
- Гүйлгээний тоо хязгааргүй
- Гүйлгээ шивэхэд маш хурдан
- Гүйлгээ баримтыг түгжих боломжтой
- Бүх төрлийн олон давтагддаг гүйлгээг хуулах боломжтой
- Бүх тайлан жагсаалтаас EXCEL, PDF – рүү экспортлох боломжтой.
- Тайлангийн дүнгээс хөөж ажил гүйлгээгээ харж, засварлах боломжтой(DRILL Down)





SMART POS - КАССЫН СИСТЕМ

СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Жижиг дунд бизнес эрхэлдэг хувь хүн болон байгууллагад зориулсан, жижиглэн борлуулалттай холбоотой бүхий л үйл ажиллагааг автоматжуулсан систем юм. Энэхүү систем нь бараа материалын

үлдэгдэл, худалдан авалт, борлуулалт, мөнгөн хөрөнгө, авлагатай холбоотой бүхий үйл ажиллагааг автоматжуулсан хялбар шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Барааны нийт ашгийг харах боломжтой.
- Барааны үлдэгдлээ хянах боломжтой.
- Бараа бүтээгдэхүүний орц найрлагыг тохируулах боломжтой.
- Өглөг, авлагын тооцоо үүсгэн хянах боломжтой.
- Касс харилцахын гүйлгээ баланс хөтлөх, хянах боломжтой.
- Рестораны хувьд хоол болон, уух зүйлсийн меню, заал болон ширээг тохируулах боломжтой.
- Мэдрэгчтэй дэлгэц(Touch screen)дээр ашиглах боломжтой
- Хүлээлгийн горимтой.
- НӨАТУС-тай холбогдсон.
- Борлуулалтын буцаалт хийх, бараа солих боломжтой.
- Бүх тайлан, жагсаалтаас EXCEL, PDF-рүү экспортлох боломжтой.



ҮР ДҮН, ХЯНАЛТ

- Бүх төрлийн жагсаалт, тайлан
- Урирдлага хяналт

БҮТЭЦ



SMART POS КАССЫН СИСТЕМ

ҮНЭ

- Барааны үнэ
- Бөөний үнэ
- Харилцагчийн үнэ

САНХҮҮ

- Өглөг, авлага

БОРЛУУЛАЛТ

- ПОС-ын борлуулалт
- Борлуулалт
- НӨАТУС холболт
- Борлуулалтын буцаалт

БАРАА МАТЕРИАЛ

- Худалдан авагч
- Дотоод хөдөлгөөн
 - Тооллого
- Нөөцийн тохиргоо
- Бараа материалын бүртгэл



SMART MRP - БАРААНЫ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ


СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

Бараа материалын үлдэгдлийн хяналт, нөөц хоног тооцох, салбаруудын үлдэгдлийн хяналт тавих гэх мэт барааны үлдэгдэлтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад туслах худалдааны болон импортын байгууллагад тохирох систем юм. Энэхүү систем

нь барааны зохистой хэмжээг тооцох, нөөцийн хяналтыг хийх, ABC барааны үлдэгдлийг хянаж, шийдвэр гаргахад тань тусална. Уг систем нь санхүү, удирдлагын тайлангийн системүүдтэй холбогдон ажилладаг цогц шийдэл юм.

ДАВУУ ТАЛ:

- Ирээдүйн барааны нөөцийг таамаглах
- Нөөцийг тооцоолон захиалга үүсгэх
- Борлуулалт дээр үндэслэн ABC ангиллын барааг тооцох
- Борлуулалтын түүх, татан авалтын, борлуулалтын төлөвлөгөө, нөөцийн үлдэгдэл зэргийг санхүүгийн системээс татаж
- Бүх дата дээр үндэслэн борлуулалтын дундаж жилээр, улирлаар, сараар, 7 хоногоор, өдрөөр тооцоолох боломжтой
- Бараа материал худалдан авалтын захиалга автоматаар үүсэх
- Санхүүгийн системтэй холбогдон ажиллана.





SMART BALANCE LITE - САНХҮҮГИЙН СИСТЕМ (EXPRESS)

Санхүүгийн систем нь ерөнхий журналын түвшинд гүйлгээ хийж аж ахуй нэгж, банк бус, төрийн бус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын санхүүгийн тайлан гаргахад туслах энгийн шийдэл юм. Уг систем нь олон мэдээллийн бааз үүсгэх боломжтой, жилийн орлого нь 60 сая төгрөгөөс доош байгууллагууд үнэгүй ашиглах боломжтой.



SMART LEASING & LOAN - ТҮРЭЭС, ЗЭЭЛИЙН СИСТЕМ

Лизинг болон зээлийн систем нь санхүүгийн түрээс болон зээлтэй холбоотой бүх үйл ажиллагааг автоматжуулж, цаг хугацаа хэмнэж, ухаалаг шийдвэрүүдийг гаргахад тань туслана. Уг систем нь сар бүрийн төлбөр төлөлтийн график, төлөлтийн хяналт, зээл болон түрээсийн хяналт тавих зэрэг боломжуудтай бөгөөд санхүүгийн системтэй уялдаж ажиллана.



SMART TOUR - АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СИСТЕМ

Аялал жуулчлалын систем нь дотоод аялал, гадаад аялалын бүхий л үйл ажиллагааг бүртгэх, аялалын маршрут гаргах, өртөг төсөв гаргах, борлуулалт ашиг хянах зэрэг боломжтой. Уг систем нь санхүүгийн систем болон удирдлага хяналтын системтэй уялдаж ажиллана.



SMART VAT - НӨАТУС-Н СИСТЕМ

НӨАТ-н систем нь Ебаримт руу борлуулалтын мэдээллийг олноор нь илгээх боломж олгосон систем бөгөөд харилцагчийн регистрийн дугаараар татвар төлөгчийн мэдээллийг татаж, эксэлээс олноор нь борлуулалтын мэдээлэл илгээх боломжтой систем юм. Уг системийг ихэвчлэн борлуулалт, түгээлтийн компаниуд ашигладаг.



SMART AUTO SERVICE - АВТО ЗАСВАРЫН СИСТЕМ

Авто засварын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад зориулсан үйлчилгээ бүртгэл, харилцагчийн түүхэн мэдээлэл хөтлөх боломжтой систем. Уг систем нь авто засварын үйлчилгээний бүртгэл хөтлөх, механик инженер засварчдын ажлын гүйцэтгэлийг хөтлөх, хянах боломжоор хангана. Дээрхи бүртгэлүүдтэй холбоотой бүх төрлийн тайлан мэдээ авах боломжтойгоос гадна Smart Loyalty хөнгөлөлтийн картын систем, Smart Retail POS кассын системтэй холбогдон ажиллах боломжтой.



SMART GROUP - ГРУППЫН НЭГТГЭЛИЙН СИСТЕМ

Группийн нэгтгэлийн систем нь групп компанийн хувьд санхүүгийн тайлан мэдээ гаргах, байгууллагуудын үндсэн үйл ажиллагааг нэгтгэн хянах, салбар байгууллагынхаа мөнгөн хөрөнгө түүнтэй холбогдох орлого, зарлага, гүйлгээ баланс, өглөг авлага, ашиг алдагдалыг тайлагнах зэрэг үйл ажиллагааны чанарын явцад хяналт тавих, цаашдын төсөв төлөвлөлт, бодлогын түвшинд шийдвэр гаргахад туслах зориулалттай нэгдсэн систем юм.



SMART PRODUCTION - ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАХИАЛГЫН СИСТЕМ

Үйлдвэрлэлийн систем захиалга авах, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, цехийн процесс, захиалгын процесс, материал зарцуулалт хийх, төлбөр төлөх зэрэг боломжтой. Захиалга, ажлын гүйцэтгэл, төлбөр төлөлтийн үр дүнд хяналт хийх тайлан жагсаалтаас харах боломжтой. Захиалга тус бүрээр өртөг, ашгыг тооцон харуулах боломжтой. Уг систем нь санхүүгийн системтэй холбогдож ажиллана.



MASTER DATA - МАСТЕР ӨГӨГДЛИЙН СИСТЕМ

Лавлах мэдээллийг систем нь бараа материал болон харилцагчтай холбоотой бүхий л лавлах мэдээллийг бүртгэн оруулах систем бөгөөд санхүүгийн систем дээр байхгүй дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэх боломжтой. Уг систем нь санхүүгийн систем, дэлгүүрийн систем, борлуулалтын системтэй уялдаж ажиллана.



SMART CRM (B2B) - ХАРИЛЦАГЧИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ

Харилцагчийн удирдлагын нэгдсэн систем Байгууллагын харилцагчдын нэгдсэн бүртгэл, гэрээ хэлцэл бүртгэл, тэдгээртэй холбоотой тайлан мэдээ авах боломжтой систем юм. Тухайн байгууллагын харилцагчдын менежмент, харилцааны түүхэн мэдээлэл, холбоотой хийгдсэн ажлууд гэх мэт бүх төрлийн мэдээллийг авах боломжтой. Smart Accounting системийн харилцагчдын бүртгэлтэй холбогдон ажилладаг.



SMART CONSTRUCTION SALES - БАРИЛГЫН БОРЛУУЛАЛТЫН СИСТЕМ

Үл хөдлөх хөрөнгө, орон сууцны борлуулалт бүртгэлийн систем. Борлуулахаар эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгүүдийг бүртгэх, төлбөрийн график үүсгэх, төлбөр төлөлтүүд хөтлөж явах, авлагын тайлангууд, төлбөр төлөлтийн хяналтуудыг гаргаж авах боломжтой. Уг систем нь Smart Accounting санхүүгийн системтэй холбогдож тухайн төлбөр төлөлт бүрийн мэдээллийг илгээх, журнал бичилтийг автоматаар үүсгэх боломжоор хангана.



SMART CONSTRUCTION BUDGET - БАРИЛГЫН ТӨСӨВ ХЯНАЛТ, УДИРДЛАГЫН СИСТЕМ

Барилгын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудад зориулсан, барилгын төсөв бүртгэх, хяналт тавих боломжтой систем юм. Барилга барихтай холбоотой хийгддэг ажлын дарааллууд үүсгэх, орц норм тохируулах, бараа материалын төсөвлөлт хийх, туслан гүйцэтгэгчийн гэрээ бүртгэх хянах боломжтой. Уг систем нь Smart Accounting санхүүгийн систем рүү барилгын төсөвтэй холбоотой бараа материалын зарцуулалтын зардлын гүйлгээ, ажлын гүйцэтгэлтэй холбоотой өглөг авлагыг постлон, холбогдож ажилладаг.



SMART CUSTOMER ACCOUNT - ХАРИЛЦАГЧЫН ТООЦООНЫ СИСТЕМ

Харилцагчийн тооцооны систем нь бэлтгэн нийлүүлэгчтэйгээ тооцоо нийлэх, нэхэмжлэх авах, борлуулалт, үлдэгдэлээ хянах систем, харилцагчийн вэб системээс бүрдэх цогц систем юм. Уг систем нь санхүүгийн систем, дэлгүүрийн удирдлагын системтэй уялдаж ажиллана. Бэлтгэн нийлүүлэгчтэй онлайнаар тооцоо нийлэх боломжтой.



SMART UTILITY BILLING - СӨХ, КОНТОРЫН СИСТЕМ

Конторын удирдлагын систем Орон сууц контор, СӨХ –ын байгууллагуудад зориулагдсан СӨХ, конторын систем нь айл өрхийн сарын хэрэглээний бүртгэл хийх хэрэглээний дүнг тооцон гаргаж айл өрхүүд дээр авлага үүсгэнэ. Хэрэглээний тариф, үзүүлэлт, хэрэглээ тооцох загвар, төлбөр төлөлт, дуудлага бүртгэх, тоолуурын заалт бүртгэх зэрэг боломжуудтай. Айл өрхүүд дээр үүссэн авлагыг төлбөр төлөлтөөр хаадаг. Хэрэглээг тайлан жагсаалтаас харах боломжтой.



SMART INVENTORY - БАРАА МАТЕРИАЛЫН МОБАЙЛ СИСТЕМ

Бараа материалын мобайл систем нь няравын гар утасны апп бөгөөд бараа материалын орлого, зарлага, хөдөлгөөн, тооллого, худалдан авалт, худалдан авалтын буцаалтыг гар утаснаас бар код уншуулж ажиллан цаг хугацаа хэмнэнэ. Уг систем нь санхүүгийн smartaccounting, smartbalance pro системүүдтэй уялдаж ажилладаг.



SMART OPERA - ЗОЧИД БУУДАЛ, РЕСТОРАНЫ ХОЛБОЛТЫН СИСТЕМ

Олон улсын сүлжээ буудлуудын ашигладаг Opera зочид буудлын системээс буудал болон рестораны борлуулалт, буцаалт, төлбөр төлөлтийн мэдээллийг автоматаар татаж, үйл ажиллагааг хялбарчлан, санхүүгийн систем рүү гүйлгээ постлох хялбар шийдэл юм. Уг систем нь санхүүгийн SmartAccounting системтэй холбогдон ажиллах бөгөөд цаг хугацаа хэмнэн борлуулалт хянах, удирдахад тань туслах болно.



SMART SALE MOBILE - БОРЛУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН МОБАЙЛ СИСТЕМ

Борлуулалт түгээлтийн мобайл систем нь худалдааны төлөөлөгч, борлуулагч, түгээгч нар газар дээрээс захиалга авах, борлуулалт хийх зориулалттай онлайн систем юм. Энэхүү систем нь борлуулалт хийх, газар дээр нь урамшуулал хөнгөлөлт олгох, баримт хэвлэх, төлөвлөгөө гүйцэтгэл хянах, борлуулалт, барааны үлдэгдлээ хянах боломжтой цогц систем юм. Уг систем нь борлуулалт түгээлтийн системтэй уялдаж ажилладаг.



SMART RESTAURANT MOBILE - РЕСТОРАНЫ МОБАЙЛ СИСТЕМ

Рестораны мобайл систем нь зөөгч ширээний захиалгыг гар утаснаас хийж үйлчлүүлэгчид түргэн үйлчилэхэд тусална. Уг систем нь ресторан пос-той уялдаж ажиллана.



SMART RETAIL MOBILE - ДЭЛГҮҮРИЙН МОБАЙЛ СИСТЕМ

Дэлгүүрийн мобайл систем нь гар утаснаас онлайнаар борлуулалт хийж баримт хэвлэх, барааны үлдэгдэл харах, борлуулалтын болон кассын тайлан харах боломжтой барааны дэлгүүр, лангуу, павилон гэх мэт газрууд ашиглахад тохиромжтой. Уг систем нь дэлгүүрийн удирдлагын системтэй уялдаж ажилладаг.



SMART ACADEMY ТУХАЙ

Smart Academy нь 2019 оны 2 сараас эхлэн үйл ажиллагаагаа Smart ERP системийн дэд систем болох Smart Accounting, Smart Balance Pro гэсэн системүүдээр үйл ажиллагаагаар эхлүүлсэн. 2019 оны 9 сараас эхлэн Microsoft Power BI сургалт явагдаж байгаа.

Манай сургалт нь Сургалтын хэсэг, Шалгалт авах, Сертификат олгох гэсэн 3 хэсгээс бүрддэг бөгөөд дараах чиглэлүүдээр сургалтууд явагдаж байна. 2020 оны 1 сарын байдлаар 400 гаруй сертификаттай мэргэжилтэнг амжилттай төгсгөсөн байна.

1. Smart ERP системийн дэд системүүдийн практик сургалт
 - Associate /анхан, дунд /
 - Professional /мэргэжлийн/
 - Master /мастер / гэсэн 3 төвшний сертификаттай
2. PowerBI практик сургалт
 - Associate /анхан, дунд/
 - Professional мэргэжлийн/
 - Master /мастер/ гэсэн 3 төвшний сертификаттай
3. MSSQL Server Developer практик сургалт
 - Associate /анхан, дунд/
 - Professional мэргэжлийн/
 - Master /мастер/ гэсэн 3 төвшний сертификаттай


СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 2020 он

2020 он	Сургалтын төрөл			
Cap	Accounting Associate	Accounting Professional	POWER BI Associate	SQL Server Associate Developer
1			13-17	
2	12-17		18-22	
3	16-20	2-6	9-13	
4	20-24		6-10	13-17
5	11-15		4-8	
6	15-19	8-12	22-26	
7	22-27		6-10	
8	17-21		10-14	3-7
9	21-25	14-18	7-11	
10	19-23		5-9	
11	16-20		2-6	
12	7-11	14-18	21-25	



ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД

ХУДАЛДАА



РЕСТОРАН, ЗОЧИД БУУДАЛ, ҮЙЛЧИЛГЭЭ





ҮЙЛДВЭРЛЭЛ



БАРИЛГА, АВТО ЗАМ, УУЛ УУРХАЙ, БУСАД





✉ info@smartlogic.mn 📱 @smartlogicmn 🌐 www.smartlogic.mn, www.powerbi.mn 📘 fb.com/smartlogicmn

☎ **7701-9090**

📍 Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 14192, 8-р хороо, Оюутны гудамж 33, Танан төв, 301 тоот

БИД ТАНД ДАРААХ СИСТЕМҮҮДИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА



BI
УДИРДЛАГА ХЯНАЛТЫН СИСТЕМ



ACCOUNTING
САНХҮҮГИЙН СИСТЕМ (ENTERPRISE)



BALANCE PRO
САНХҮҮГИЙН СИСТЕМ (STANDARD)



BALANCE LITE
САНХҮҮГИЙН СИСТЕМ (EXPRESS)



POS
КАССЫН СИСТЕМ (ЖИЖИГ ДҮНД БИЗНЕС)



HR
ХҮНИЙ НӨӨЦИЙН СИСТЕМ



TIME & ATTENDANCE
ЦАГ БҮРТГЭЛИЙН СИСТЕМ



RETAIL
ДЭЛГҮҮРИЙН СИСТЕМ



SALE & DISTRIBUTION
БОРЛУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН СИСТЕМ



MRP
БАРААНЫ НӨӨЦИЙН СИСТЕМ



HOTEL
ЗОЧИД БУУДЛЫН СИСТЕМ



PHARMACY
ЭМИЙН САНГИЙН СИСТЕМ



LOYALTY
ХӨНГӨЛӨЛТИЙН КАРТЫН СИСТЕМ



RESTAURANT
РЕСТОРАНЫ СИСТЕМ



LEASING & LOAN
ТҮРЭЭС, ЗЭЭЛИЙН СИСТЕМ



TOUR
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СИСТЕМ



VAT
НӨАТУС-Н СИСТЕМ



AUTO SERVICE
АВТО ЗАСВАРЫН СИСТЕМ



GROUP
ГРУППЫН НЭГТГЭЛИЙН СИСТЕМ



WAREHOUSE
АГУУЛАХЫН УДИРДЛАГЫН СИСТЕМ



PRODUCTION
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАХИАЛГЫН СИСТЕМ



MASTER DATA
МАСТЕР ӨГӨГДЛИЙН СИСТЕМ



LICENSE
ЛИЦЕНЗИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ



INVENTORY
БАРАА МАТЕРИАЛЫН МОБАЙЛ СИСТЕМ



CONSTRUCTION BUDGET
БАРИЛГЫН ТӨСӨВ ХЯНАЛТ, УДИРДЛАГЫН СИСТЕМ



CRM
ХАРИЛЦАГЧИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ



CUSTOMER ACCOUNT
ХАРИЛЦАГЧИЙН ТООЦООНЫ СИСТЕМ



ORDER
ЗАХИАЛГА УДИРДЛАГЫН СИСТЕМ



CONSTRUCTION
БАРИЛГЫН БОРЛУУЛАЛТЫН СИСТЕМ



GPS
GPS ХЯНАЛТЫН СИСТЕМ



UTILITY BILLING
СӨХ, КОНТОРЫН СИСТЕМ



ERP MOBILE
УДИРДЛАГА ХЯНАЛТЫН МОБАЙЛ СИСТЕМ



RESTAURANT MOBILE
РЕСТОРАНЫ МОБАЙЛ СИСТЕМ



RETAIL MOBILE
ДЭЛГҮҮРИЙН МОБАЙЛ СИСТЕМ



SALE MOBILE
БОРЛУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН МОБАЙЛ СИСТЕМ